

**“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТООЛЛОГЫН КОМИССЫН ПРОТОКОЛ**

---

2019 оны 05-р сарын 03-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани /цаашид “Компани” гэх/-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нийт саналын эрхтэй энгийн хувьцааны

- (i) 82 хувь буюу 8,515,795 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигч “Хасвуу” ХХК
- (ii) 18 хувь буюу 1,869,320 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг эзэмшигч С.Нэргүй нар

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирсэн байна. Иймд Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “Хурал” гэх/-ын ирц 100 хувьтай бүрдсэн болохыг Хурлын дарга болон Компанийн хувьцаа эзэмшигчдэд мэдээлж байна.

Хурлын ажиллагаанд амжилт хүсье.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



ГИШҮҮД

Л.БАЛГАН

Ц.БАЯРБААТАР

Э.ДОЛГОРСҮРЭН

М.БАЯРМАНЛА

**“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

---

2019 оны 05-р сарын 03-ны өдөр

Дугаар 19/01

Улаанбаатар хот

Хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани /цаашид “Компани”гэх/-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

Нэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 05-р сарын 03-ны өдрийн ээлжит хурлыг хүчин төгөлдөр гэж тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БЭХБАТ

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТООЛЛОГЫН КОМИСС**

---

2019 оны 05-р сарын 03-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Санал хураалтын дүнгийн тухай

Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани /цаашид “Компани” гэх/-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 05-р сарын 03-ны өдрийн ээлжит хурлаар Компанийн хувьцаа эзэмшигчдийн гаргасан саналыг шалгаж тоолсон дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

Нэг. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийн талаарх төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гаргасан дүгнэлтийг (хэлэлцэх асуудал №1) батлах тухай Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төслийг Компанийн саналын эрхтэй 10,385,115 ширхэг энгийн хувьцаа буюу нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 100 хувийг эзэмшигчид *сайшаан баталсан болохыг* Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдсүгэй.

Хоёр. Компанийн ТУЗ-өөс баталсан 2019 оны бизнес төлөвлөгөөг хэлэлцэх (хэлэлцэх асуудал №2) Компанийн саналын эрхтэй 10,385,115 ширхэг энгийн хувьцаа буюу нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 100 хувийг эзэмшигчид *сайшаан баталсан болохыг* Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдсүгэй.

Гурав. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах (хэлэлцэх асуудал №3) тухай Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төслийг Компанийн саналын эрхтэй 10,385,115 ширхэг энгийн хувьцаа буюу нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 100 хувийг эзэмшигчид танилцуулсан *болохыг* Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдсүгэй.

Дөрөв. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг кумулятив аргаар сонгох (хэлэлцэх асуудал №4)

(1) ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Энэбишийн Долгорсүрэнгийн төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901 ширхэг санал буюу 11 хувь саналаа өгсөн болохыг,

(2) ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Буянзаяагийн Эрдэнэбилгийн төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901 ширхэг санал буюу 11 хувь саналаа өгсөн болохыг,

(3) ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Түмэнжаргалын Энхмэндийн төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901 ширхэг санал буюу 11 хувь саналаа өгсөн болохыг,

(4) ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Самдангийн Нэргүйн төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901 ширхэг санал буюу 11 хувь саналаа өгсөн болохыг,

(5) ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Шархүүгийн Оюунзулын төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901 ширхэг санал буюу 11 хувь саналаа өгсөн болохыг,

(6) ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Ц.Баярбаатарын төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901 ширхэг санал буюу 11 хувь саналаа өгсөн болохыг,

(7) ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Галсангийн Бэхбатын төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901 ширхэг санал буюу 11 хувь саналаа өгсөн болохыг,

(8) ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Лумаагийн Балганы төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901 ширхэг санал буюу 11 хувь саналаа өгсөн болохыг,

(9) ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Нүдэнгийн Эрдэнэбатын төлөө саналын эрхтэй энгийн хувьцаа эзэмшигчдээс нийт 1,153,901 ширхэг санал буюу 11 хувь саналаа өгсөн болохыг,

тус тус Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдсүгэй.

Тав. Компанийн ТУЗ-ийн 2019-2020 оны цалин урамшуулал болон зардлыг батлах (хэлэлцэх асуудал №5) тухай Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төслийг Компанийн саналын эрхтэй 10,385,115 ширхэг энгийн хувьцаа буюу нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 100 хувийг эзэмшигчид *сайшаан баталсан болохыг* Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдсүгэй.

Зургаа. Компанийн давуу эрхийн хувьцаа гаргах асуудлыг хэлэлцэн батлах (хэлэлцэх асуудал №6) тухай асуудлыг шийдвэрлэхээс Компанийн саналын эрхтэй 10,385,115 ширхэг энгийн хувьцаа буюу нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 100 хувийг эзэмшигчид *түтгэлзсэн болохыг* Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдсүгэй.

Долоо. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах (хэлэлцэх асуудал №7) тухай асуудлыг шийдвэрлэхээс Компанийн саналын эрхтэй 10,385,115 ширхэг энгийн хувьцаа буюу нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 100 хувийг эзэмшигчид *түтгэлзсэн болохыг* Хувьцаа эзэмшигчдийн хуралд мэдэгдсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

ГИШҮҮД



Л.БАЛГАН

Ц.БАЯРБААТАР

Э.ДОЛГОРСҮРЭН

М.БАЯРМАНЛА

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

---

2019 оны 05-р сарын 03-ны өдөр

Дугаар 19/02

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн  
дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дахь заалт, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх  
Сүлжээ Хувьцаат Компани (цаашид "Компани"гэх) -ийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны  
05-р сарын 03-ны өдрийн ээлжит хурлын Тоологын комиссийн дүнг үндэслэн ТОГТООХ  
нь:

Нэг. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх  
Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг сайшаан баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БЭХБАТ

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 05-р сарын 03-ны өдөр

Дугаар 19/03


Улаанбаатар хот

Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг  
хэлэлцэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.9 дахь заалт, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани /цаашид "Компани"гэх/ -ийн Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 05-р сарын 03-ны өдрийн ээлжит хурлын Тоологын комиссийн дүнг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн 2019 оны бизнес төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БЭХБАТ

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 05-р сарын 03-ны өдөр

Дугаар 19/04

Улаанбаатар хот

ТУЗ-ийн гишүүдийг сонгох  
болон ТУЗ-ийн зардлын төсвийг  
батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид "Компани"гэх) -ийн Дүрмийн 7-р зүйлийн 7.8.7 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 05-р сарын 03-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тоологын комиссийн дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнээр сонгож баталсугай.

Хараат бус гишүүд:

- (i) Г.Бэхбат;
- (ii) Л.Балган;
- (iii) Н. Эрдэнэбат;

Ердийн гишүүд:

- (iv) Э.Долгорсүрэн;
- (v) Б.Эрдэнэбилэг;
- (vi) Т.Энхмэнд;
- (vii) С.Нэргүй;
- (viii) Ш.Оюунзул;
- (ix) Ц.Баярбаатар.

2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшуулал болон зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.БЭХБАТ

**ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 05-р сарын 03

Дугаар 19/05

Улаанбаатар хот

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.10 дахь заалт, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ Хувьцаат Компани (цаашид "Компани"гэх) -ийн Дүрмийн 5-р зүйлийн 5.2.1 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 05-р сарын 03-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тоологын комиссийн дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн давуу эрхийн хувьцаа гаргах, энгийн хувьцаа нэмж гаргах эсэх асуудлыг энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэхээс түтгэлзсүгэй.

**ХУРЛЫН ДАРГА**



**Г.БЭХБАТ**